



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
Төрийн Өмчт Хувьцаат Компани

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Компанийн албан тушаалын жагсаалт, орон тоо,
цалингийн сүлжээг шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, 84 дүгээр зүйлийн 84.4.1, 84.4.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар 43.2.1, 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1, 103 дугаар зүйлийн 103.3.1, 108 дугаар зүйлийн 108.1, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 29 дүгээр тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хурлын 29 дүгээр тогтоол, "Компанийн дүрэм"-ийн 8 дугаар зүйлийн 8.11.9, 8.11.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн зохион байгуулалтын нэгжийн албан тушаалын жагсаалт, орон тоог нэгдүгээр хавсралтаар, шинэчлэн батлагдсан албан тушаалын цалингийн сүлжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Цалингийн сүлжээг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс мөрдөн, ажиллагсдын цалин хөлсийг зохих журмын дагуу тооцож олгохыг Санхүү, эдийн засгийн газрын Нягтлан бодох бүртгэлийн алба /Д.Отгонцэцэг/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/94 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

П.ГАНХҮҮ

2023000031